

БАТЛАВ, САНГИЙН ДЭД САЙД БӨГӨӨД  
НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛ, АУДИТЫН  
СТАНДАРТЫН ХОРООНЫ ДАРГА



Х.БУЛГАНТУЯА

**НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛ, АУДИТЫН СТАНДАРТЫН  
ХОРООНЫ 7-Р ХУРАЛДААН**

ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛ:

1. Нягтлан бодох бүртгэл, аудитын стандартын хорооны 2018 оны тайланг сонсох, 2019 оны төлөвлөгөөг хэлэлцэн батлах
2. СТОУС 15 “Худалдан авагчтай байгуулсан гэрээний орлого”-ийг хэрэгжүүлэх аргачлалыг хэлэлцэн шийдвэрлэх
3. СТОУС-ын сургагч багш бэлтгэх сургалтын хөтөлбөрийг хэлэлцэж, ажлын хэсэг байгуулах

Хурал 2018 оны 02 дугаар сарын 28-ний өдрийн 9.00 цагт Сангийн яамны 9 давхарын зааланд эхэлнэ.

Хурлын .....хуудас материалыг хавсаргав.

**САНГИЙН САЙДЫН ДЭРГЭДЭХ  
НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛ, АУДИТЫН СТАНДАРТЫН  
ХОРООНЫ ТОГТООЛ**

2018 оны 02 дугаар  
сарын 28-ний өдөр

№ 07

Улаанбаатар хот


Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 21 дүгээр зүйл болон Сангийн сайдын 2016 оны 323 дугаар тушаалыг үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Хорооны 2019 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг Хавсралт 1-ээр баталсугай.
2. “Худалдан авагчтай байгуулсан гэрээний орлогыг бүртгэх стандарт”-ын төслийг Сангийн сайдын тушаалаар батлуулахаар уламжилсугай.
3. СТОУС-ын сургагч багш бэлтгэх сургалтын хөтөлбөрийг хянан магадлах үүрэг бүхий ажлын хэсгийг Хавсралт 2-оор баталсугай.
4. СТОУС-ын сургагч багш бэлтгэх сургалтын хөтөлбөрийг хянан магадласан тухай санал дүгнэлтээ 2019 оны 04 дүгээр сарын 05-ны дотор хорооны хуралд танилцуулахыг ажлын хэсэг /Л.Дондог/-т даалгасугай.
5. Тогтоолын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Нягтлан бодох бүртгэлийн бодлогын газар /Ч.Чимидсүрэн/-т үүрэг болгосугай.

САНГИЙН ДЭД САЙД БӨГӨӨД  
НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛ, АУДИТЫН СТАНДАРТЫН  
ДАРГА:

НАРИЙН БИЧГИЙН ДАРГА


ГИШҮҮД:





ХОРООНЫ  
Х.БУЛГАНТУЯА


Б.БОЛОРМАА

Ч.ЧИМИДСҮРЭН  
М.БАТХУЯГ

 Ц.НАРАНЧИМЭГ  
Л.ДОНДОГ

 Л.БАДАМХАНД  
Д.БҮНЧИНСҮРЭН

 Г.ГАНТУЛГА  
Д.ТӨРМӨНХ

 Д.ЭНХТУЯА  
Д.НЯМАА

Нягтлан бодох бүртгэлийн стандартын хорооны  
2019 оны 02-р сарын 28-ны өдрийн 07 тоот  
тогтоолын нэгдүгээр хавсралт

**НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛ, АУДИТЫН СТАНДАРТЫН  
ХОРООНЫ 2019 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ**

	<b>Хийх ажил</b>	<b>хугацаа</b>	<b>Хариуцах ажилтан</b>
1	НББАСХ-ны 2018 оны тайлан, 2019 оны төлөвлөгөөг хэлэлцэн батлах	2-р сард	Б.Болормаа Хорооны гишүүд
2	СТОУС 15 “Худалдан авагчтай байгуулсан гэрээний орлого”-г хэрэгжүүлэх аргачлал, СТОУС-ын сургагч багш бэлтгэх сургалтын хөтөлбөрийг хэлэлцэх	2-р сард	Б.Болормаа Хорооны гишүүд
3	СТОУС 16 “Түрээс”, СТОУС 17 “Даатгалын гэрээ”-г хэрэгжүүлэх аргачлалыг хэлэлцэн, батлах	7, 11-р сард	ММНБИ Б.Болормаа Хорооны гишүүд
4	СТОУС болон УСНББОУС-ын 2018 оны орчуулгыг хянаж, батлах /2000+2500 орчим хуудас/	4, 11 -р сард	Б.Болормаа ММНБИ Хорооны гишүүд
5	СТОУС/УСНББОУС-ын 2018 оны хэвлэлийн орчуулгын явц болон зарим нэр томъёог хэлэлцэн батлах	4-р сард	Б.Болормаа Хорооны гишүүд
6	“Боловсролын олон улсын стандарт” /114 хуудас/-ын орчуулгыг хянаж, батлах	7-р сард	ММНБИ Б.Болормаа Хорооны гишүүд
7	Санхүүгийн тайлангийн болон орлогын албан татварын тайлангийн зөрүүг зохицуулах журмын төслийг хэлэлцэх	7-р сард	Б.Болормаа
8	Нягтлан бодох бүртгэлийн стандартын хорооны хурлын бэлтгэлийг хангаж, хуралдаанаар хэлэлцэх асуудлыг гишүүдэд хүргүүлэх, хуралдааныг зохион байгуулах	Тухай бүр	Б.Болормаа
9	Батлагдсан стандартуудыг хэвлэх, борлуулах, давтан сургах чиглэлээр ММНБИ-ийн гүйцэтгэж байгаа үйл ажиллагаанд хяналт тавих.	4, 7-р сард	Б.Болормаа Хорооны гишүүд
10	Нягтлан бодох бүртгэлийн стандартын хорооны үйл ажиллагааны талаар нийтэд сурталчлах, хэвлэлд ярилцлага нийтлүүлэх	Тухай бүр	Хорооны гишүүд

Нягтлан бодох бүртгэлийн стандартын хорооны  
2019 оны 02-р сарын 28-ны өдрийн 07 тоот  
тогтоолын хоёрдугаар хавсралт

**СТОУС-ЫН СУРГАГЧ БАГШ БЭЛТГЭХ СУРГАЛТЫН ЖИШИГ  
ХӨТӨЛБӨРИЙГ ХЯНАН МАГАДЛАХ АЖЛЫН ХЭСЭГ**

Ажлын хэсгийн ахлагч:

Л.Дондог

НББАСХ-ны гишүүн, МНББХ-ийн ерөнхийлөгч,  
проф, доктор

Гишүүд:

Д.Нямаа

НББАСХ-ны гишүүн, МУИС-ийн Бизнесийн  
сургуулийн НББ-ийн хөтөлбөрийн дэд проф,  
доктор

Г.Гантулга

НББАСХ-ны гишүүн, ОУНББСМС-ийн багш,  
дэд проф, доктор

Л.Бадамханд

НББАСХ-ны гишүүн, ММНБИ-ийн стандартын  
хэлтсийн дарга

Д.Бүнчинсүрэн

НББАСХ-ны гишүүн, “Юнифайд файнаншл  
солюшнс аудит” ХХК-ийн аудитор